



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/443

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Соёлын тухай хуулийн 14.2.1, 14.2.2 дахь заалт аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, 2.3.3.1, 2.3.3.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймагт 2019 онд хэрэгжих үйл ажиллагаануудын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Баруун бүсийн Утга зохиолын чуулганыг 2019 оны 9 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Чуулганы зохион байгуулалтыг хариуцан ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Чуулганы бэлтгэл ажлыг хангаж, уг чуулганыг хуулийн хүрээнд, үр өгөөжтэй зохион байгуулж, тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Монголын Зохиолчдын Эвлэлийн Ховд аймаг дахь Алтай салбарын захирал /Г.Төрмөнх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ





### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч
- Гишүүд: Г.Төрмөнх -Монголын зохиолчдын эвлэлийн Ховд  
аймаг дахь Алтай салбарын захирал
- Б.Баяртуяа -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Олон нийттэй харилцах хэлтсийн дарга
- С.Ариунжаргал -Хөгжимт драмын театрын даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч
- Ц.Пүрэвсүрэн -Ховд их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн  
ухааны сургуулийн захирал
- А.Жаргалсайхан -Монголын зохиолчдын эвлэлийн  
салбарын удирдах зөвлөлийн дарга
- Д.Саранцэцэг -Нийтийн номын сангийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч
- Б.Нямдэлгэр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, аж ахуйн тасгийн дарга
- Д.Өрнөхдэлгэр -Ховд их сургуулийн Хэл зохиолын  
тэнхимийн эрхлэгч
- Х.Алтантуяа -Аймгийн Засаг даргын  
Хэвлэл мэдээлэл хариуцсан зөвлөх
- Нарийн бичгийн  
дарга: Д.Гантуяа -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн  
соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн

-оОо-